

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2019 онд Ган хийц ХК-ийн үндсэн үйлдвэрлэл дараах чиглэлүүдээр явагдсан. Үүнд:

- Төмөр хийц эдлэл үйлдвэрлэл
- Барилга угсралт

Ган хийц ХК-ийн 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал, ЗАА зардлын төсөв, борлуулалтын хэмжээг дараах байдлаар баталж өгсөн байна.

№	Нэр	Төсөв
1	ТУЗ-ийн зардал	121977600
2	ЗАА зардал	647118700
3	Төмөр хийц үйлдвэрлэл, барилга угсралтын борлуулалт	2 640 000 000

Материал татан авалтыг боловсронгуй болгож, материал байнгын авдаг харилцагчтай болох. Өмнөх жилүүдэд томоохон ажлын материалыг Эрээн хотоос авдаг байсныг үргэлжлүүлэх болно.

2019 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна

Захиалагч	Ажлын нэр	Хаана хийсэн	Хугацаа	Үнэ
Зэвсэгт хүчний 017 анги	Энхийг дэмжих ажиллагааны сургалт бэлтгэлийн нэгдсэн төвийн төмөр хийц	Улаанбаатар хот	20	202 222 290
Хос санаа ХХК	Андлалын өргөө цогцолбор барилгын төмөр хийц угсралт	Улаанбаатар хот	20	135 891 800
Их Майдар сан	Их майдар цогцолборын төмөр хийц	Төв аймаг		585 285 290

## **УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

### **ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл**

Ган хийц ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр компанийн тухай хууль болон компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ.

2019 оны 04 дүгээр сарын 26 -ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд сонгон баталсан. Ган хийц ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат гишүүнээр М.Даваасүрэн, Б.эрдэнэбаяр, Ц.Пүрэвжаргал, Б.Ганбат, Э.Долгорсүрэн, Ц.Хангай нарыг, Хараат бус гишүүнээр Д.Сайнбаяр, Д.Энхбаатар, Ц.Жанлав нарыг сонгож баталсан.

2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар М.Даваасүрэн, нарийн бичгээр О.Ууганцэцэг, Аудитын хорооны даргаар Ц.Жанлав, Гишүүдээр Э.Долгорсүрэн, Д.Сайнбаяр нарыг, Цалин урамшууллын хорооны даргаар Д.Сайнбаяр, гишүүд Ц.Хангай, Д.Энхбаатар нарыг, Нэр дэвшүүлэх хорооны даргаар Д.Энхбаатар, Б.Эрдэнэбаяр, Ц.Жанлав нарыг сонгон томилсон.

### **Орон тоо бүтцийн талаар:**

2019 оны ТУЗ болон Захиргаа, үйлчилгээний хэсгийн орон тоо цалингийн төсвийг дараах байдлаар баталсан.

<b>№</b>		<b>Төсөв</b>
<b>1</b>	Захиргаа, үйлчилгээний хэсгийн орон тоо, цалингийн сан	407033700
<b>2</b>	Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн зардал	53760000

Компанийн мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс [www.gankhiits.mn](http://www.gankhiits.mn) веб сайт шинэчлэгдэж, Хувьцаа эзэмшигчдэд зориулан булан гаргасан бөгөөд компанийн холбогдолтой бүхий л мэдээллийг авах боломжтой юм.

## **САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

2019 оны хагас жилийн санхүүгийн тайланг хавсралт-1-ээр үзүүлэв.

## **НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

2019 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар нэгж хувьцаанд 50 төгрөг тараахаар шийдвэрлэсэн.

Уг шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан бөгөөд одоогийн байдлаар ногдол ашгийг тарааж эхлээгүй байна.